

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХКИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

БАТЛАВ БААТАР ХОТ

АМГАЛАН
ДУЛААН
СТАНЦ
ТӨХК

НЭГДСЭН БИЧИГЧ ТӨХӨӨРӨМЖ ХУДАЛДАХ,
ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

МОНХОРУС-ИНТЕРНЭШНЛ ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

БАТЛАВ БААТАР ХОТ

МОНХОРУС
ИНТЕРНЭШНЛ
ХХК

ХАМТАРСАЛ

Б.БЯМБАДОРЖ

20⁰³ оны 08-р сарын 01 өдөр

Дугаар.. 63 /
2023

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө, нөгөө талаас Монхорус-Интернэшнл ХХК-ийг төлөөлж Реле хамгаалалт, СКАДА автоматжуулалтын хэлтсийн дарга Б.Мөнхжаргал /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29-р зүйлийн 29.2 дахь заалт, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

- 1.1 Нийлүүлэгч нь “Нэгдсэн бичигч төхөөрөмж” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заасан нэр төрөл, тоо хэмжээ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу захиалагчийн агуулахад нийлүүлэн, угсралт суурьлуулалтыг хийж гүйцэтгэнэ.

Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

- 2.1 Нийлүүлэгч нь барааг 2023 оны 09 сарын 01-ны дотор багтаан нийлүүлэн, угсралт суурьлуулалтыг хийж гүйцэтгэнэ.
2.2 Талууд харилцан тохиролцон гэрээний хугацааг нэг /1/ удаа 30 /гуч/ хүртэлх хоногоор сунгаж болно.

Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

- 3.1 Энэ гэрээний нийт үнэ 116,823,463 /нэг арван зургаан сая найман зуун хорин гурван мянга дөрвөн зуун жаран гурав/-н төгрөг бөгөөд үнийн дүнд гааль онцгой албан татвар, захиалагчийн агуулахад хүргэх, тээврийн зардал, угсралт суурьлуулалтын зардал, НӨАТ бүгд орсон байна.
3.2 Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 3.3 Барааг хүлээлгэн өгсөний дараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн 90 хоногийн дотор төлбөрийг нэхэмжлэлийн дагуу нийлүүлэгчийн Худалдаа хөгжлийн банк 499210267 тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

- 4.1 Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.

Захиалагч:

1/4

Нийлүүлэгч:

- 4.2 Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.
- 4.3 Барааг захиалагчийн агуулахад ирсний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана. Буцаах зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.
- 4.4 Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг цахилгааны инженер А.Нямцэрэн утас-88084450, Д.Мөнхдөл утас-99000203.
- 4.5 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Монхорус-Интернэшил ХХК-ийн Реле хамгаалалт, СКАДА автоматжуулалтын хэлтсийн дарга Б.Мөнхжаргал. Утас:88004751

Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол

- 5.1 Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2 Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед гэмтэж цоорогоос хамгаалсан сав, баглаа, боодолтой байна.
- 5.3 Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд чанараа алдахгүй байх ёстой.
- 5.4 Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.5 Нийлүүлэгч нь нийлүүлсэн бараанд 1 жилийн баталгаа гаргана. Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан гэмтэл согог, дутагдлыг өөрийн зардлаар засаж залруулах, сольж өгөх үүрэгтэй.

Зургаа. Бараа хүлээн авах

- 6.1 Нийлүүлэгч нь ачигдсан барааг захиалагчийн агуулахад хургэх ба захиалагч талаас бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2 Нийлүүлэгч нь барааг захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.
- 6.3 Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгөхдөө дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:
- Барааг суурилуулж бүрэн хэвийн ажиллагаанд оруулж өгөх.
 - Ашиглалтын үеийн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх.
 - Ашиглалтын үеийн сургалт зохион байгуулж, захиалагчийн инженер техникийн ажилтан нарыг хамруулах.
 - Холбогдох техникийн бичиг баримтыг бүрэн бүрдүүлж өгөх.
 - Гүйцэтгэсэн ажлын акт зураг бүрдүүлж хүлээлгэн өгөх.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд гэрээний хугацаа дуусахаас өмнө талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.

Захиалагч:

2/4

Нийлүүлэгч:

Найм. Гэрээг цуцлах үндэслэл

- 8.1 Нийлүүлэгч нь барааг энэхүү гэрээний 2.1-т заасан материал нийлүүлэх хугацаанаас хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зохих хариут өгч тодорхой арга хэмжээ авахгүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцална.
- 8.2 Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

Ес. Бусад нөхцөл

- 9.1 Талуудын аль нэг нь негеөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж, Захиалагч 2 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд 1 удаа сунгаж болно.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
- 9.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

СЭЗХ-ИЙН ДАРГА
БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ

 О.УДВАЛ


АЖ АХҮЙ, ХАНГАМЖИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Г.БАТТУЛГА

НЭГДСЭН ЦЕХИЙН
ДАРГА

 Ж.АРИУНЖАРГАЛ


ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН

 М.МОЛОМЖАВ


Хаяг: Монгол улс, Улаанбаатар
хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

МОНХОРУС-ИНТЕРНЭШНЛ ХХК-ИЙН
САНХҮҮ ХАРИУЦСАН ДЭД ЗАХИРАЛ
Б.МАРТЖАРГАЛ

ҮЙЛДВЭР ТЕХНОЛОГИ ХАРИУЦСАН ДЭД
ЗАХИРАЛ Г.АМАРСАЙХАН

РЕЛЕ ХАМГААЛАЛТ, СКАДА
АВТОМАТЖУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Б.МОНХЖАРГАЛ

ХУДАЛДААНЫ ИНЖЕНЕР
О.ДАВААЖАРГАЛ

Хаяг: Монгол улс, Улаанбаатар
хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэр
гудамж-22, Магнолиа
Утасны дугаар: 88004751
РД: 2587807

Захиалагч:



3/4

Нийлүүлэгч: